

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ОРЛОГО ШИМТГЭЛИЙН БАЙЦААГЧ
ЦЭРЭНДОРЖИЙН ЭРДЭНЭЖАРГАЛ 2024 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт”							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
1.1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоо тойгоор нийт 702 ажил олгогчийн нягтлан бодогч, захирлуудад шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгож тайлагнахад анхаарч аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчдыг тайлан шалгах цонхыг ашиглан алдаа зөрчилгүй тайлан баталгаажуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөг ажиллаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн	2024-01-02 2024-06-28	100%

					даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам, Хөдөлмөр. Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/44, А/43 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн код”-ыг ажил олгогчдод танилцуулан тушаалыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.		
1.1.3	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2023 онд нийт 12 ажил олгогч, 24 даатгуулагчийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог 48, даатгуулагчийн тоог 285 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/61 тушаалаар салбарын хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын ажил үйлчилгээг шуурхай үзүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар нийгмийн даатгалд хамрагдаагүй 2 ажил олгогч, албан журмын даатгалд 4 даатгуулагчийг шинээр хамруулсан.	2024-01-02 2024-06-28	100%
Зорилт 2. “Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт”							
Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах							
2.1.3	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн	Батлагдсан 69,451,851.83	Нийгмийн даатгалын	Нийгмийн даатгалын	Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын		110.6%

	орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.	төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана.	шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 1895.1 төгрөгөөр буюу 100 хувиар биелүүлсэн.	шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 1895.1 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 1895.1 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	2024-01-02 2024-06-30	
2.1.5.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх.	Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 9.1 хувиар буурсан /өссөн/ байна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна.	Газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан шимтгэлийн авлага барагдуулах, орлогын төлөвлөгөө биелүүлэх чиглэлээр 2024 онд хийж гүйцэтгэх хэлтсийн ажлын төлөвлөгөөг батлуулан өр авлага барагдуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Данс хаах: 2024 оны 2 дугаар улиралд 157 сая төгрөгийн өртэй 17 байгууллагын харилцах дансны гүйлгээг зогсоож 64 сая төгрөгийн авлагыг барагдууллаа. Шүүхэд нэхэмжилсэн: Авлага барагдуулах ажлын хүрээнд 2024 оны тайлант хугацаанд 32 сая төгрөгийн өртэй 1 ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулахаар харьяа анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. олгогчийн хаяг байршил эзэн холбогдогч тодорхойгүй гэх үндэслэлээр шүүхээс буцсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй хуримтгагдсан авлага 50 сая төгрөг үйл ажиллагаага зогсоосон гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага	2024-01-02 2024-06-28	80%

				хятад захиралтай, захирал нь нутаг буцсан. шимтгэлийн хугацаандаа төлөөгүй өр хуримтлагдаж байна.		
Зорилт 4. “Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт”						
Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах						
4.1.2	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 100%-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	2024 оны 2 дугаар улирлын байдлаар ажил олгогчоос цалин залруулга, нөхөн тайлан, албан хүсэлттэй холбоотой EDOC системээр нийт 3 хүсэлт ирсэнээс 3 ажил олгогчийн албан хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	2024-01-02 2024-06-28 100%
Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах						
4.2.2	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 52 удаагийн сургалтад 4914 иргэд, даатгуулагчийг хамруулсан	Хариуцсан 2 ажил олгогч байгууллагад сургалт зохион байгуулж, ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	2024 оноос эхлэн салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2024 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд 50 ажил олгогчийн нягтлан бодогчдыг хамруулан танхимаар сургалт зохион байгуулж ажил олгогчийг шинэ системд бүртгүүлэх мэдээллийг шинэчлэх, даатгуулагчийн мэдээлэл болон регистрийн дугаарыг үнэн зөв оруулах, даатгуулагчийн төрлийн кодыг зөв сонгох, тайлангаа хуулийн хугацаанд цахимаар ирүүлэхийг анхааруулж зөвлөгөө өгч ажилласан.	2024-01-02 2024-06-28 100%

Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх

4.4.1	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 100% байсан	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна. Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна. Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна. Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.	Тус газраас иргэд даатгуулагч, ажил олгогчийн захирал нягтлан бодогчдод нийгмийн даатгалын ажил үйлчилгээг хүртээмжтэй шуурхай хүргэх, нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх сургалтыг тогтмол зохион байгуулж, шинээр ажил олгогчоор бүртгүүлэх заавар, гарын авлага QR код, сайн дурын даатгалд хамрагдах иргэдэд зориулсан мэдээлэл, гарын авлага QR кодыг бэлтгэн гаргасан. QR уншуулан даатгуулагчийн ажил мэргэжлийн ангилал, даатгуулагчийн төрлийн кодыг харах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Тайлан хугацаанд sicosc истемрээр шимтгэлийн төлөлтийн тайланг хянаж баталгаажуулсан бөгөөд тайлан авалтын хувь 95 % байна.	2024-01-02 2024-06-28	100%
4.4.2	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	2024 оны тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцоо хийсэн 132 ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн өдрийн А/199 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын дагуу хүлээн авч, хянан цахимаар баталгаажуулан, даатгуулагчийн төрлийг давхардуулан бүртгэхгүй	2024-01-02 2024-06-28	100%

					байх талаар нягтлан бодогч нарт заавар зөвлөгөө өгч ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилт нь Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйл “Төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага”, салбарын хууль тогтоомжид заасан мэдлэг, ур чадвар, арга зүйг үе шаттайгаар эзэмшиж, хариуцсан ажлаа мэргэжлийн түвшинд үр бүтээлтэй хийж гүйцэтгэхэд чиглэнэ.							
2.1.1	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийг судлах	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар цогц мэдлэг эзэмшсэн байна	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомж, нэмэлт өөрчлөлтүүд, шинээр хэрэгжиж байгаа хуулийн зохицуулалтуудын талаар цогц мэдлэг эзэмших	Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд, дээд газраас ирүүлсэн заавар, дүрэм журмыг судлах, өдөр тутмын үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2024 оны 01 дүгээр сарын 22, 2 дугаар сарын 26-ны өдрүүдэд цахим мэдээллийн цагаар sicos программыг танилцуулга, программ дээр хэрхэн ажиллах талаар сургалтад хамрагдсан. НДЕГ-ын сургалтын танхимд Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланг илгээхэд гарч буй асуудлууд, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг сургалтад оролцсон. Сургагч багшаар НДЕГ-ын бодлогын хэрэгжилт судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцож мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллаа.	2024-01-02 2024-06-28	100%
2.1.2	Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад хамрагдах	Монгол бичгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах эзэмших	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасны дагуу богино болон дунд хугацааны сургалтад	Монгол бичгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах анхан шатны мэдлэг эзэмших	2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, НДЕГ-аас зохион	2024-01-02 2024-06-28	100%

		цахимаар хамрагдаж, Монгол бичгийн анхан дунд шатны цахим сургалтад хамрагдаж албан хэрэглээний түвшинд эзэмшсэн байна		байгуулж буй монгол бичгийн цуврал хичээлд цахимаар оролцож байна.		
--	--	---	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ОРЛОГО ШИМТГЭЛИЙН БАЙЦААГЧ



/Ц.ЭРДЭНЭЖАРГАЛ/

.....